



Нийтийн сонсголын дэг

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан “Сонсголын нийтлэг журам”, Монгол улсын Их хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 4-т заасны дагуу энэхүү дэгийг тогтоов.

Энэхүү дэгийг сонсоод оролцогч нийт оролцогчид дагаж мөрдөнө.

- Нийтийн сонсгол хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан тушаалтнаас 15 минутын хугацаанд мэдээлэл өгнө.
- Сонсголд оролцохоор бүртгүүлсэн иргэн, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагын төлөөлөл нь сонсголын танхимд ирсэн хугацааны дагуу санал хэлнэ.
- Сонсголд оролцогч 5 минутын хүртэл хугацаанд багтаан үг хэлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.
- Асуултыг амаар болон бичгээр сунгаж болно.
- Сонсголын асуудалтай холбогдуулан бичгээр ирсэн санал, хүсэлт, мэдээллийг сонсгол даргалагчаас уншиж танилцуулан тэмдэглэлд тусгуулна.
- Санал, тайлбар дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.
- Асуулт хариулт дууссаны дараа сонсголд оролцогчдоос санал дүгнэлтээ 2 минутаас илүүгүй хугацаанд хэлнэ.
- Сонсголд оролцогч асуулт асуух, үг хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сонсгол даргалагчаас асуулт асуух, үг хэлэхийг хязгаарлаж болно.
- Оролцогчид сонсголын үеэр хуралдаан даргалагч бусад оролцогчоос асуулт асуухгүй.
- Сонсголд оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашхирах, шүгэлдэх зэргээр бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд саад учруулсан болон сонсгол зохион байгуулагч, сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал сонсгол даргалагч дэг баримтлахыг шаардаж, шаардлагыг үл биелүүлбэл ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.
- Сонсгол оролцогч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 15.2 -т заасны дагуу:
 - Сонсгол хийх журам, дэгийг сахих
 - Сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх
- Сонсголын асуудлаар гаргасан тайлбар, санал, дүгнэлт нь үнэн бодитой байх үүргийг тус тус хүлээнэ.
- Ажиглагч сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.
- Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдийг сонсголд оролцуулахыг хориглоно.

БАТЛАВ
ИТХ-ЫН ДАРГА Д.ЧИНБАЯР

НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Сонсголын зорилго: Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Зорилт: Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Төрийн байгууллага иргэдэд Нийтийн сонсголын тухай хуулийн мэдээллийг өгөх

“Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэл”-д тухайн төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах

Зохион байгуулагч: Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Хугацаа, байршил: 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10 цагт сумын Соёлын төвд

Нийтийн сонсгол зохион байгуулах тухай:

10:00 цагт Нийтийн сонсголын үйл ажиллагааг нээх \сумын ИТХ-ын дарга Ц.Чинбаяр

10:10 Нийтийн сонсголын үйл ажиллагааг дэгийн дагуу зохион байгуулах

10:20 Нийтийн сонсголын үйл ажиллагааг үргэлжлэх

13:00 Нийтийн сонсголын үйл ажиллагааг хааж үг хэлэх

Хүрэх үр дүн: Нийтийн сонсголыг зохион байгуулснаар эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл хүргэнэ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба

Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн зарцуулалт,
гүйцэтгэлийн сонголд оролцох ажиглагчдын бүртгэл

2023.12.25

Бат-Өлзий сум

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	утас	Гарын үсэг
1	Б.Агваамзрэх	ХХЗ.	95777399	
2	А.Няндан	ХХЗ	95728571	
3	Н.Долгорсүрэн	өндөр настан	99969268	
4	М.Авирмэргэл	ХХЗ.	99791707	
5	О.Тантсогоо	Малчин	99163108	
6	Т.Турэвтоттох	ХХЗ.	95710934	
7	С.ТӨМӨР	ХХЗ.	99690461	
8	Х.Давгадүүл	Малчин	99086482	
9	Д.Доржпалаг	НБМ	80424292	
10	Г.Хорол-Ардуна	УТХ	99862030	
11	Б.Самсүрэн	СОББ-1 НА-60	99792758	
12	М.Молваану	СОББ2 - нарв	99886888	
13	Д.Доржпалаг	СОББ2 - нарв	99935382	
14	М.Чингэлсүрэн	СОББ-1 Нарв	95678101	
15	Д.Доржпалаг	ЗДТ-ын төсөв, төрийн үйлчилгээ	95118050	
16	Т.Блидгарав	ЗДТ. БЗД.	99777466	
17	А.Мандухай	СБС - мөнх	86088211	
18	Н.Батсүрэн	ЗДТ - и на - 60	91411299	
19	Д.Доржпалаг	өндөр настан	99767995	
20	Д.Уянгаг	өндөр настан	99521769	
21	Б.Тамсаг	ЭМТ - орта	94118809	
22	С.Сонгоо	Амтал. хо-50	99026982	
23	Д.Молваану	ЭМТ - и нарв	99275076	
24	Блидгарав	ХХЗ	8634889	
25	Тамсаг	Малчин		
26	Тамсайхан	Малчин	98130034	
27	Турэвдүрм	ХХЗ		
28	Сүмъяабаатар	Малчин	99942316	

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2023.12.25

Өвт

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 11 цаг 30 минутад сумын Соёлын төвд Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх Нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэв.

Төсвийн хяналтын нийтийн сонсголын зохион байгуулагчаар иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Ц.Чинбаяр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сонсгол даргалагчаар ИТХ-ын төлөөлөгч Н.Орхонтуул, дуудагдаж ирсэн албан тушаалтнаар Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Ганням, Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Г.Болормаа, Эрүүл мэндийн төвийн нярав Д.Мөнхбаяр нар, оролцогчоор Д.Мөнхнасан, М.Жаргалсүрэн, Д.Очирхуяг, шинжээчээр О.Отгонтуяа, ажиглагчаар 35 иргэн, албан хаагч оролцлоо. Сонсголын үйл ажиллагааг нээж ИТХ-ын дарга Ц.Чинбаяр үг хэллээ.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ц.Чинбаяр /ИТХ-ын дарга/: Нийтийн сонсголын гол зорилго нь иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлэх, 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангахад оршино. 2022 онд Нийтийн сонсголыг зохион байгуулсан. Энэ жил 5 дах удаагаа зохион байгуулж байна. Сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулдаг.

Захиргааны хэм хэмжээ тогтоох сонсголыг зохион байгуулж болно. Өнөөдөр Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд сонсголыг зохион байгуулж байна.

Н.Орхонтуул\Сонсгол даргалагч\: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Сумын ИТХ-ын Нийтийн сонсголыг дэгийг уншиж танилцуулав. /Дэгийг хавсаргав/

Нийтийн сонсголд хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан хаагч, сонсголд оролцогчид үг хэлэхдээ 5 минут, амаар болон бичгээр асуулт асууж болно. Асуулт 4 минут, дараагийн удаа 1 минут, үг хэлэхдээ 3 минут байна.

Ажиглагчид үг хэлж, асуулт асуухгүй. Ингээд үйл ажиллагаандаа оръё. Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Г.Болормаа Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийнэ.

Г.Болормаа \Дуудагдсан албан тушаалтан, Нягтлан бодогч\: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг танилцуулъя. Эрүүл мэндийн төв 2022 онд 1,049,655,336 төгрөгийн санхүүжилт авсан байгаа. Эрүүл мэндийн төв нь 2 үндсэн хөрөнгөтэй 80302 нь нэг иргэнд ноогдох норматив санхүүжилт, 81603 нь үндсэн тусламж үйлчилгээ гэсэн үйл

ажиллагаагаар тусламж үйлчилгээ явуулдаг байгаа. 80302 хөрөнгөөс цалин хөлсөнд 336,869,400 төгрөг зарцуулсан, ажил олгогчоос төлж буй шимтгэл 42,108,700 төгрөг төлсөн, хангамж бараа материалын зардалд 3,816,600 төгрөг зарцуулсан байна. 2022 онд Аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчлийн хариуг танилцуулъя тээвэр шатахуун дээр санхүү бүртгэл бараа материалын зардлыг орлого зарлага бөөн дүнгээр бүртгэсэн тул зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих боломжгүй байна. Энэ нь 55,737,000 төгрөгийн шатахуун зарцуулсан зөвлөмж өгсөн зөвлөмжийн дагуу алдаа дутагдлаа арилгаж ажилласан байгаа. Мөн тээвэр шатахуун зарцуулахдаа жолоочийн бүртгэл бүрэн хөтлөөгүй шаардах хуудас анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу гэсэн үүнийг нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэж байгаа. Хоол хүнс дээр махны үлдэгдэл гарсан гэсэн албан шаардлага ирүүлсэн оны эхэнд махны үлдэгдэл 111 кг тайлан тооцоонд 2,621.8 мах орлогот авч 1,473.3 мах зарцуулсан бөгөөд оны эцэст 2,253.5 кг буюу 21,543,000 төгрөгийн махны нөөц үүсгэсэн байгаа ийм учраас төсвийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн гэсэн албан шаардлага ирүүлсэн. Тус албан шаардлагуудын хариуг Аудитын газарт хүргүүлсэн. Эрүүл мэндийн төвийн хоол хүнсний нийлүүлэлтийг худалдан авах ажиллагааны дагуу тендер зарлаж Батгэгээнхангай ХХК-тай гэрээ хийж хамтран ажилдаг. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бараа материалыг нярвын тайлан дээр сар болгоноор авдаг нягтлан бодох бүртгэлийн программ дээр бөөн дүнгээр бүртгэсэн байсан нь зөрчил болж илэрсэн. Одоо нягтлан бодох бүртгэлийн программ дээр тус тусад нь бүртгэсэн байгаа ирүүлсэн албан шаардлагын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төсвийн зарцуулалтыг танилцуулъя нэг хүнд ноогдох норматив 451,259,200 төгрөг цалин хөлс 336,869,400 төгрөг, ажил ологчоос суутгах нийгмийн даатгалын шимтгэлд 42,108,700 төгрөг, хангамжийн бараа материалд 3,816,600 төгрөг зарцуулсан, томилолтын зардалд 875,000 төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 832,200 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардалд 899,200 төгрөг, ахуй үйлчилгээний бусад зардалд 9,574,900 төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ 526,670,400 төгрөг, шагналд 29,001,200 төгрөг, хангамж бараа материалын зардалд 77,738,566 төгрөг, норматив зардалд 155,379,000 төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 19,496,980 төгрөг, 81603 дээр нэг зардал орж ирсэн нь багаж техник хэрэгсэл урсгал зардал 19,496,984 төгрөг, зочны зардал 625,000 төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,540,400 төгрөг эрүүл мэндийн газраас 14,340,000 төгрөгийн нэмэлт санхүүжилт өгсөн 7,500,000 төгрөгийн цалин хөлс, 937,500 төгрөг шимтгэлд, хангамж бараа материалын зардалд 750,000 төгрөг, эм, хоол хүнсэнд 5,152,500 төгрөг тус тус зарцуулж нийтдээ 1 тэрбум 49,655,346 төгрөгийг 2022 онд үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Н.Орхонтуул/Сонсгол даргалагч\: Болормаадаа баярлалаа. Оролцогчид 5 минутад багтаж үг хэлнэ. Мэдээлэлтэй холбоотой асуулт, санал байна уу.

М.Жаргалсүрэн/оролцогч\: Махны зардлаа яагаад илүү төлөвлөлцөн бэ?

Н.Орхонтуул \Сонсгол даргалагч\: Оролцогч Жаргалсүрэнгийн асуултад Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Болормаа мэдээлэл өгнө үү.

Г.Болормаа \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЭМТ-ийн нягтлан бодогч\:
Манай эрүүл мэндийн байгууллага 2002 оноос хойш гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тусламж үйлчилгээ үзүүлэх бүрд санхүүжилт орж ирж, тусламж үйлчилгээ үзүүлэхгүй тохиолдолд санхүүжилт орж ирдэггүй ийм онцлогтой байгууллага. 2022 оны эрүүл мэндийн даатгалаар оны эцэст гүйлгээ хаахтай зэрэгцээд санхүүжилт орж ирдэг

төсвийн гүйцэтгэлээр оны эцэст хоолон дээр зардал орж ирээд тэрийгээ махаараа нөөцлөхлөөр шийдвэрлэсэн байгаа. 2022 онд үлдэгдэл махаа шахаад мөн гэрээлэгчээсээ мах аваад махны нөөц үүссэн энэ нь хэмнэлтийн тухай хуулиар зөрчил үүссэн гэж үзэж байгаа болохоос өөр зөрчил бол байхгүй.

Н.Орхонтуул \Сонсгол даргалагч\: За баярлалаа. Дараагийн оролцогч Мөнхнасанг урьж байна.

Д.Мөнхнасан \оролцогч\: Хэвтэн эмчлүүлж буй өвчтөнд өдрийн эмчилгээний тариф гэж байгаа юу?

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: Мөнхнасангийн асуултад Болормаа хариулна уу.

Г.Болормаа \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст нэг өдрийн норматив гэж байхгүй. Эдийн засгийн хувьд тооцоод үзүүл өдөрт 4000-6000 төгрөгийн нэг удаагийн хоол өгч байна. Хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдэд өдөрт 2 удаа хоол өгдөг 8000-12000 төгрөг зарцуулагддаг гэсэн үг.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: Оролцогч Очирхуягийг урьж байна.

Д.Очирхуяг \оролцогч\: Шатахууны төсөв хүрэлцээтэй байдаг уу?

Г.Болормаа \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Шатахууны тооцооны хуудсаа сар бүрд бүрдүүлээд архивлаад явдаг сард 6-7 сая төгрөгийн шатахуун зарцуулдаг.

Н.Орхонтуул \Сонсгол даргалагч\: за баярлалаа. Оролцогч Очирхуягийг урьж байна.

Д.Очирхуяг \Оролцогч\: Эмийн эргэлтийг санд жилд хэдэн төгрөг байдаг вэ? Эмийн нөөц хэр их вэ зарим эм тариаг иргэд гаднаас өөрсдөө авдаг гэсэн.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: Болормаа асуултад хариулна уу.

Г.Болормаа \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Ковидоос хойш эм нөөцөлж ирсэн. Бүүр олдохгүй эм тариаг иргэдээр гаднаас авхуулах тохиолдол гардаг.

Б.Ганням \Дуудагдаж ирсэн албан тушаалтан ЭМТ-ийн дарга\: Эм тариаг 1,2,3-р шатлал гэж байдаг. 1-р шатлалт хэргэлдэг эм тариа бүгд эрүүл мэндийн газраас ирдэг. 3-р шатлалын эм тариаг гаднаас захиулж авхуулдаг.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Очирхуягийг урьж байна.

Д.Очирхуяг \Оролцогч\: Ийм ийм эмийг гаднаас авна гэсэн тогтоол шийдвэр байдаг уу?

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: Эрүүл мэндийн төвийн дарга Ганням асуултад хариулна уу.

Б.Ганням \дуудагдсан албан тушаалтан\: Эрүүл мэндийн төвөөс гарсан ямар нэгэн тогтоол шийдвэр байхгүй.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Жаргалсүрэнг саналаа хэлнэ үү гэж урьж байна.

Санал дүгнэлт:

М.Жаргалсүрэн \Оролцогч\: Эрүүл мэндийн төвтэй холбоотой зөндөө асуух асуулт байна гэхдээ сонсголын хүрээндээ асуултаа асууллаа. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй цаашдаа засаад явах байх. Аудитаас ирсэн албан шаардлага бүрийг дор бүр нь засаад явсан байна. Өөрөөр ноцтой зөрчил байхгүй байна.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Мөнхнасанг урьж байна.

Д.Мөнхнасан \Оролцогч\: Ноцтой алдаа зөрчил байхгүй байна гэж үзэж байна.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Очирхуягийг урьж байна.

Д.Мөнхнасан \Оролцогч\: Аудитын дүгнэлтийг үндэслээд гаргасан алдаа дутагдлаа засаад, анхан шатны баримтаа сайн бүрдүүлж байгаарай гаргасан алдаагаа дахин давтахгүй байх гэж бодож байна.

Н.Орхонтуул \сонсгол даргалагч\: Санал хариулт авч дууслаа. Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон нийт оролцогчдодоо баярлалаа.

Ц.Чинбаяр\зохион байгуулагч\: Сонсгол энэ хүрээнд өндөрлөж байна.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тодорхой хэмжээний чиглэл, ойлголттой боллоо.

Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэд та бүхэндээ баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Нийтийн сонсгол 12:25 цагт өндөрлөв.

ТАНИЛЦСАН:

ИТХ-ЫН ДАРГА Ц.ЧИНБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН Г.СУГАР